



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/006/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.Open.audit.mn](http://www.Open.audit.mn)  
Архангай аймаг  
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)  
Ахлах аудитор П.Цэцэгдулам  
Цахим хаяг: [Tsetsegdulamp@audit.gov.mn](mailto:Tsetsegdulamp@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>13</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>13</b>
<b>5.1 Албан шаардлага .....</b>	<b>13</b>
<b>5.2 Зөвлөмж.....</b>	<b>14</b>
<b>5.2.1 Орлоготой холбоотой асуудал .....</b>	<b>14</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>15</b>
<b>7. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>16</b>
<b>8. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>16</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.08.25 № 161  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭМАНДАЛ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ЭНЭБИШ  
ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэмандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Сумын 2024 оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 318,294.2 мянган төгрөгөөр давсан боловч нэг нэр төрлийн орлогыг төлөвлөснөөс 7,142.1 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн;
2. Хоршоо хөгжүүлэх сангийн 3 зээлдэгчтэй холбоотой 47,896.0 мянган төгрөгийн чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй;
3. Тайлант онд сумын ИТХ-аар "Иргэдийн оролцоо, малчдын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр"-ийг баталж, тэмцээн уралдаан, шагнал, бэлэг дурсгалд төсвөөс нийт 6,860.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;

Эдгээр зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам", Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Аудитын гол асуудал**

Тайлант онд сумын төсөвт 19 нэр төрлийн орлогоор 608,185.2 мянган төгрөг төвлөрүүлэхээр батлагдсанаас, гүйцэтгэлээр 926,479.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөө нийт дүнгээр 152.3 хувиар давж биелсэн байна.

Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2,933,399.7 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 2,469,343.3 мянган төгрөгийг зарцуулж, 464,056.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Эрдэнэмандал сумын Засаг дарга нь 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 72.0 хувьтай үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,077,008.6	1,215,352.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	447,240.9	736,892.8
33	АВЛАГА	406,421.3	305,754.2
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	223,346.4	172,705.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,118,539.5	11,376,253.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,118,539.5	11,376,253.6
39200	Биет хөрөнгө	10,776,317.5	11,032,267.6
39300	Биет бус хөрөнгө	342,222.0	343,986.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,195,548.1	12,591,606.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	76,093.9	91,370.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	76,093.9	91,370.1
41300	Өглөг	76,093.9	91,370.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,119,454.2	12,500,236.0
51	Засгийн газрын хувь оролцоо	12,119,454.2	12,500,236.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,403,360.5	1,403,360.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	177,814.0	68,844.0
51200	Хуримтлагдсан үр дүн	10,443,425.4	10,933,177.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,854.2	94,854.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,195,548.1	12,591,606.3

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,240,784.6	4,065,176.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	598,257.7	910,428.6
110	Орлогын албан татвар	377,068.3	808,958.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	376,858.3	808,793.4
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	210.0	165.0
113	Хөрөнгийн албан татвар	166,007.7	56,378.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	55,181.7	45,091.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,094,554.2	1,182,013.9
120	Нийтлэг татварын бус орлого	1,051,854.2	1,182,013.9
122	Тусламжийн орлого	42,700.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,547,972.7	1,972,734.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,585,739.9	3,076,145.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,585,739.9	3,076,145.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,763,509.5	2,876,470.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	589,944.3	850,980.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,091.0	103,528.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,502.5	608,119.4
2104	Хангамж, бараа материалын зардал	88,447.9	68,948.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,224.1	59,758.6
2107	Томилт, зочны зардал	27,738.9	37,576.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	845,857.3	267,656.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,027,703.5	879,902.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,822,230.5	199,675.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	655,044.6	989,031.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	656,323.0	499,279.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,278.4	489,751.9

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,975,436.1	3,635,642.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	598,257.7	910,428.6
110	Орлогын албан татвар	377,068.3	808,958.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	376,858.3	808,793.4
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	210.0	165.0
113	Хөрөнгийн албан татвар	166,007.7	56,378.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	55,181.7	45,091.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	28,469.7	31,222.0
1181	Газрын төлбөр	14,219.4	1,203.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	12,492.7	12,665.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	829,205.7	752,479.4
120	Нийтлэг татварын бус орлого	829,205.7	752,479.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,547,972.7	1,972,734.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,173,039.6	2,662,774.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,173,039.6	2,662,774.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,350,809.1	2,463,105.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	680,962.1	996,841.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,404.3	129,642.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,370.2	667,294.6
2104	Хангамж, бараа материалын зардал	316,336.8	319,068.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,491.6	59,758.3
2107	Томилолт, зочны зардал	38,415.9	37,576.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	736,114.3	111,307.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	312,714.0	141,616.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,822,230.5	199,669.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	802,396.5	972,867.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	705,998.1	683,215.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	705,998.1	683,215.9
2200	Дотоод эх үүсвэрээр	705,998.1	683,215.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-705,998.1	-683,215.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-175,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	175,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-78,601.6	289,651.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	525,842.5	447,240.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	447,240.9	736,892.8

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
------	---------------------	---	------------------------

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,120,612.5	12,120,612.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	120.0	120.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,120,732.5	12,120,732.5
9	Тайлант үеийн үр дүн	-1,278.4	-1,278.4
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,119,454.2	12,119,454.2
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	12,119,454.2	12,119,454.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,119,454.2	12,119,454.2
17	Өмчид гарсан өөрчилөлт	-108,970.0	-108,970.0
19	Тайлант үеийн үр дүн	489,751.9	489,751.9
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	12,500,236.0	12,500,236.0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,933,399.7	2,469,343.3	464,056.4	84.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,166,359.9	1,979,743.7	186,616.3	91.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,078,770.8	1,892,154.6	186,616.3	91.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	971,588.5	850,980.8	120,607.7	87.6
210101	Үндсэн цалин	961,988.5	553,222.3	408,766.2	57.5
210102	Нэмэгдэл	-	247,921.3	(247,921.3)	-
210104	Урамшуулал	-	41,837.3	(41,837.3)	-
210105	Гэрээт ажлын хөлс	9,600.0	8,000.0	1,600.0	83.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,448.6	103,528.6	17,920.0	85.2
210201	Тэтгэврийн даатгал	82,680.9	72,386.5	10,294.4	87.5
210202	Тэтгэмжийн даатгал	9,692.0	8,375.5	1,316.5	86.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,753.6	4,893.1	2,860.5	63.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,938.3	2,026.2	(87.9)	104.5
210205	Эрүүл мэндийн даатгал	19,383.8	15,847.4	3,536.4	81.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	627,513.4	608,119.4	19,394.0	96.9
210301	Гэрэл, цахилгаан	92,195.8	91,458.0	737.8	99.2
210302	Түлш, халаалт	464,517.6	448,520.2	15,997.4	96.6
210303	Цэвэр, бохир ус	70,800.0	68,141.3	2,658.7	96.2
2104	Хангамж, бараа материалын зардал	84,232.8	81,938.7	2,294.2	97.3
210401	Бичиг хэрэг	9,008.2	9,008.2	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	29,600.0	29,297.9	302.2	99.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000.0	6,000.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	18,300.0	17,828.0	472.0	97.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,086.8	8,566.8	1,520.0	84.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,237.8	11,237.8	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	105,850.0	98,790.0	7,060.0	93.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,850.0	30,450.0	400.0	98.7
210602	Тавилга	6,000.0	6,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	69,000.0	62,340.0	6,660.0	90.3
2107	Томилолт, зочны зардал	34,100.0	33,066.0	1,034.0	97.0
210702	Дотоод албан томилолт	34,100.0	33,066.0	1,034.0	97.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,503.2	41,228.5	9,274.7	81.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,847.5	37,817.4	4,030.1	90.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,280.0	-	4,280.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	100.0	34.0	66.0	34.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600.0	411.0	189.0	68.5

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	550.0	350.0	200.0	63.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,025.7	2,596.2	429.5	85.8
210807	Газрын төлбөр	100.0	20.0	80.0	20.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,534.3	74,502.5	9,031.8	89.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,534.3	57,502.5	9,031.8	86.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,000.0	17,000.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,589.1	87,589.1	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,589.1	87,589.1	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,905.1	23,905.1	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	53,484.0	53,484.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,200.0	10,200.0	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	576,006.2	489,599.6	86,406.6	85.0
223001	Бусад хөрөнгө	576,006.2	489,599.6	86,406.6	85.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	191,033.6	-	191,033.6	-
230001	Эргэж төлөгдөх зээл	191,033.6	-	191,033.6	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,933,399.7	2,577,101.6	356,298.1	87.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,366,993.9	2,442,564.9	(75,571.0)	103.2
320001	Орон нутгийн төсвөөс	1,987,205.6	2,062,776.6	(75,571.0)	103.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	379,788.3	379,788.3	-	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	566,405.8	134,536.7	431,869.1	23.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,653.6	134,536.7	66,116.9	67.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	365,752.2	-	365,752.2	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	201,819.7	(201,819.7)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	309,578.0	(309,578.0)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	38.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	38.00	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>207,755.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>207,755.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>95,675.58</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>720.00</b>
210402	Тээвэр, шатахуун	720.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,180.00</b>
210604	Урсгал засвар	8,180.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,510.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,510.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,151.58</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,151.58
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>67,114.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,114.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>112,080.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>112,080.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	112,080.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>207,755.58</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>207,755.58</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,151.58
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	198,554.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Эрдэнэмандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 145 мэдээллээс 112 мэдээллийг хугацаанд нь байршуулж 33 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй. Залруулагдаагүй нийт 61,898.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч 7,142.1 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 54,756.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй нийт 61,898.6 мянган төгрөгийн 3 зөрчилтэй асуудал нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 19,067.1 мянган төгрөгөөс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

##### 5.1 Албан шаардлага

**5.1.1** Тайлант онд сумын ИТХ-аар "Иргэдийн оролцоо, малчдын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр"-ийг баталж, тус хөтөлбөрийн хүрээнд тэмцээн уралдаан зохион байгуулж, шагнал, бэлэг дурсгалын зүйлд буюу урсгал зардалд нийт 6,860.5 мянган төгрөгийг ОНХС-аас зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.8-д "Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6-т "ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй", 4.6.1-т "Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг энэхүү журмын 4.5-д заасан зорилгоор", 4.6.2."Энэхүү журамд заасан болон Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүрэгт хамаарах", 4.7.6 "Аливаа аж ахуй нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал"-д зарцуулахгүй гэсэн заалтыг зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.1.2** Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон 3 зээлдэгчтэй холбоотой 47,896.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-д “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10.1-д “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах.

## **5.2 Зөвлөмж**

### **5.2.1 Орлоготой холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сумын төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлээр 1 нэр төрлийн орлого 7,142.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогын сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

*Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 04 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ХХС-ийн чанаргүй зээлтэй холбоотой	1	47,896.0			1	47,896.0							
Орлоготой холбоотой	1	7,142.1					1	7,142.1					
ОНХС-тай холбоотой	1	6,860.5			1	6,860.5							
<b>дүн</b>	<b>3</b>	<b>61,898.6</b>			<b>2</b>	<b>54,756.5</b>	<b>1</b>	<b>7,142.1</b>					

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансны хууль, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй	1	0			1	0		

## 7. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ	1	12,000.0			1	12,000.0	1	12,000.0				
ЗДТГ	1	13,700.0	1	13,700.0			1	13,700.0				
ИТХ	1	3,999.9			1	3,999.9	1	3,999.9				
Хөгжлийн дэд бүтэц	2	110,005.6			2	110,005.6	2	110,005.6				
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>139,705.5</b>	<b>1</b>	<b>13,700.0</b>	<b>4</b>	<b>126,005.5</b>	<b>5</b>	<b>139,705.5</b>				

## 8. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Байгууллагын нэр	Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
	Тоо	Дүн	Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	5	52,818.40	2	9,148.60	3	43,669.80		
ИТХ	2	9,930.50	2	9,930.50	-	-		
Эрдэнэмандал Хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ	4	79,161.10			4	79,161.10		
Шилмэл сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ	2	90,220.00	-	-	1	0	-	-
Ар саравч ОНӨААТҮГ	1	65,851.10			1	65,851.10		
СДОА	-	-	-	-	-	-	-	-
ОНХС	1	6,860.50	-	-	1	6,860.50		
ХХС	1	47,896.00			1	47,896.0		
<b>НИЙТ ДҮН</b>	<b>16</b>	<b>352737.6</b>	<b>4</b>	<b>19079.1</b>	<b>11</b>	<b>195542.5</b>	<b>0</b>	<b>0</b>